



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар Б/06

Жаргалтхаан

Н.Соёлмааг үүрэгт ажилд нь эргэн
томилох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус Соёлын төвийн Бүжгийн багш Н.Соёлмаагийн хүүхэд асрах амралтын хугацаа дуусаж ажилдаа орох хүсэлтэй байгаа тул үүрэгт ажилд нь эргэн томилсугай.

2.Бүжгийн багш Н.Соёлмаагийн цалинг ТҮСБ-3 зэрэглэлийн 1.414.000 (сая дөрвөн зуун арван дөрвөн мянган) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож цалинжуулахыг нягтлан бодогч (Н.Энхзул) -д зөвшөөрсүгэй.

3.Н.Соёлмаагийн ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Комиссын дарга: Ц.Болд-эрдэнэ (Дуу хөгжмийн багш)

Гишүүд: Н.Энхтунгалаг (Номын санч)

Л.Өсөхгэрэл (Өвийн ажилтан)

4.Бүжгийн багшийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж, хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэн, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чанд мөрдөж ажиллахыг Бүжгийн багш (Н.Соёлмаа)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

ЖАРИУНГЭРЭЛ



1024110056 0074244